

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.МӨНХБАЯР

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“БЛАСТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



А.ТЭМҮҮЛИН

**“БЛАСТ” ХХК-ИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3 ДУГААР ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭЖИЖ БУЙ “ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН
ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2688336/

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА:

Э.ЖАРГАЛСАЙХАН

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Д.САНЧИРБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

“БЛАСТ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:

A blue ink signature, appearing to be "Д.Болортуяа", written in a cursive style.

Д.БОЛОРТУЯА

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
ТӨСЛИЙН НЭР:.....	2
Төслийн газар зүйн байрлал:.....	3
Төслийн тодорхойлолт, техник, технологи	4
Түүхий эдийн агуулах.....	5
Усан хангамж.....	5-6
Хог хаягдал	7
Цахилгаан, дулаан хангамж.....	8
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..	9-11
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ГОЛ ЗОРИЛТ	11
ДӨРӨВ.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
1.1 Агаар.....	12
1.2 Хөрсөн орчинд.....	13
1.3 Усан орчинд	14
ТАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ.....	16
1. Осол эрсдэлийн менежмент	17
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	18
7.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
АРВАН ХОЁР .ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	23
ХАВСРАЛТ	24

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН НЭР: “БЛАСТ” ХХК-ийн Налайх салбарын эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын төсөл

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж	“Бласт” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011125047
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Тэсрэх материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, импортлох, худалдаалах
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Ландмарк 3 давхар
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Гүйцэтгэх захирал А.Тэмүүлэн 99112528 temuulen@blastcompany.mn
	6. Төслийн даргын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Налайх дахь салбарын дарга С.Алтанбагана 99075340 Altanbagana.S@blastcompany.mn
	7. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим хаяг:	Байгаль орчны мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ 99981998 baterdene.b@blastcompany.mn
1.2	1. Төслийн нэр	Налайх дахь салбар (Энгийн болон эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах)
	2. Төслийн харьяаллын байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Баян уулын ар энгэр
	3. Төслийн ангилал	Үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2006.08.14
	5. Төсөл хэрэгжих хугацаа	Үйл ажиллагааны туршид тасралтгүй
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	2008.08.14 №13 Үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн акт Ажлын хэсгийн ахлагч ҮХЯ-ны ГУУХҮГ-ын орлогч дарга Б.Нэргүй
	7. Нийт ажилтны тоо	28
	8. ТЭЗҮ баталсан огноо	2020 он

Төслийн тодорхойлолт, техник, технологи

“БЛАСТ” ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь савалгаат эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор нь 2006 онд байгуулагдсанаас хойш өнөөг хүртэл Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудад тэсрэх материал нийлүүлэн хамтран ажиллаж байна. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор одоогийн байдлаар нь 28 ажилчин, албан хаагчтай ба 1 ээлжээр ажиллахад жилд 9000 тонн савлагаатай эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай, одоогоор эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэл явахгүй байгаа.

Энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх технологи

Тус үйлдвэрийн хүчин чадал нь 48 тн/хоног. Энгийн тэсрэх бодис нь сүвэрхэг аммиакийн шүү, дизель түлшний механик хольцоос бүрдэх бөгөөд энгийн тэсрэх бодисыг АЗ.08.29 батлагдсан ажлын зааврын дагуу бэлгэнэ. Энгийн найрлагат тэсрэх бодис үйлдвэрлэх технологи нь сүвэрхэг аммиакийн шүүг зориулалтын тавцанд байршуулж, сав баглааг задалж танканд хийж хийнэ. Дизель түлш хадгалах савнаас автомат тоолуураар дизель түлшийг орцын дагуу шахна. Үйлдвэр нь сүвэрхэг аммиакийн шүү, дизель түлшийг найрлагын дагуу хольж, савлах үйлдлүүдээс бүрдэнэ.

Энгийн тэсрэх бодис бэлтгэх заавар, дараалал:

1. Ажилчид технологичийн удирдлаган дор холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.
2. Үйлдвэрлэл эхлэхийн өмнө тоног төхөөрөмж, ажлын байрны бэлэн байдал, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг технологич бичлэн шалгана.
3. Үйлдвэрлэлд шаардагдах түүхий эд, сав баглааг Няравын хяналтан дор сэрээт өргөгчийн тусламжтайгаар агуулахаас зөөвөрлөн авчирна.
4. Үйлдвэрт ажиллах ажилчдын ажил үүргийн хуваарийг Технологич хийж, зааварчилгаа өгнө.
5. Тэсрэх бодисыг компаниас батлагдсан орц, найрлагын дагуу үйлдвэрлэх бөгөөд лаборант бичлэн хянаж тавина.
6. Түүхий эд, тэсрэх бодисын чанарыг лаборант хянаж, тоо хэмжээг технологич хянан холбогдох бүртгэлийг хөтлөнө.

Хүчитгэсэн энгийн тэсрэх бодис бэлтгэх заавар, дараалал:

Хүчитгэсэн энгийн найрлагатай тэсрэх бодис нь сүвэрхэг аммиакийн шүү, дизель түлш болон нэмэгдэл хольцоос бүрдэнэ. Сүвэрхэг аммиакийн шүү, нэмэгдэл хольцийг зориулалтын тавцанд байрлуулж сав баглааг задлан танканд хийнэ. Дизель түлш хадгалах савнаас автомат тоолуураар дизель түлшийг орцын дагуу шахна. Энгийн тэсрэх бодисын хүчийг нэмэгдүүлэх зорилгоор мөхлөгт хэлбэрийн хөнгөн цагаантай харьцуулахад цахилгаан цэнэг хуримтлуулдаггүй агаарт дэгдэх шин чанаргүй тул хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны хувьд давуу шинж чанартай байдаг.

Энгийн тэсрэх бодисын үйлдвэрийн тоног төхөөрөмж

№	Нэр	Марк	Хүчин чадал	Материал	Тоо	Нэгж
1	Түүхий эдийн сав	T1	1.1м ³	нерж	1	ш
2	Шнек	T1	6т/ц	нерж	1	ш
3	Түлшний сав		0.5м ³	нерж	1	ш
4	Түлшний сав	viking	2HP	нерж	1	ш
5	Нэмэлт хольц хийх систем	T1	1HP	нерж	1	ком
6	Савлах хэсгийн сав	JWL-RH	0.5м ³	нерж	1	ш
7	Савлах төхөөрөмж	GB-32	8т/ц	нерж	1	ш
8	Оёдлын машин		8т/ц	нерж	1	ком
9	Огноологч	52S+	8т/ц	Хуванцар	1	ш

Үйлдвэр агуулахын цогцолборын барилга байгууламж:

Налайх салбарын тэсрэх материалын агуулахын багтаамж 240 тн бөгөөд 4 агуулахыг бүгдийг нь тоосгоор барьсан. Агуулахуудыг ТАААНД-ийн шаардлагын дагуу тоногдсон бөгөөд 2, 2-оор нь бүлэглэж шороон далангаар тусгаарлан, зэлэн аянга зайлуулагчаар аянгаас хамгаалсан.



Тэсрэх материалын агуулах №1



Тэсрэх материалын агуулах №2



Тэсрэх материалын агуулах №3



Тэсрэх материалын агуулах №4

Түүхий эдийн агуулах: Түүхий эд хадгалах агуулахуудын нийт багтаамж 1500 тн.



Усан хангамж

Налайх салбарын усны хэрэгцээг 3 гүний худгаар хангадаг. Нэг дэх худаг (48 дугаартай худаг, 2005 онд “Эрдэнэ дрийлинг” ХХК өрөмдөж гаргасан, цооногийн ундарга 0.3 л/с, статик түвшин 60 метр, динамик түвшин 90 метр, насосны хүчин чадал 2тн/цаг) хашаан дотор усан сангийн доод давхарт байдаг. Хоёр дахь худаг (2007/07 дугаартай өрөмдмөл худаг, 2007 онд “Чемус” ХХК өрөмдөж гаргасан, цооногийн ундарга 0.2 л/с, статик түвшин 43 метр, динамик түвшин 108 метр) үйлдвэрийн урд хашааны гадна байрладаг. Гурав дахь худаг (2017/04 дугаартай худаг, 2017 онд “Эрдэнэ дрийлинг” ХХК өрөмдөж гаргасан, цооногийн ундарга 0.3 л/с, статик түвшин 45 метр, динамик түвшин 160 метр). Гүний худгаас 10 м3 багтаамжтай ус нөөцлөх саванд усаа нөөцөлж хэрэглэдэг. Үйлдвэрийн усны эргэлтэд нийт 200 м3 багтаамжтай усны сав ашигладаг. “Чандмань-


Налайх” НӨҮГ -тай байгуулсан “Аж ахуйн нэгж байгууллагыг цэвэр усаар хангах бохир ус татан зайлуулах гэрээ”-ний дагуу авч ашигладаг.



Гүний худаг №1



Гүний худаг №2 Зураг



Гүний худаг №3 Зураг



Ус нөөцлөх сав, багтаамж - 10 м³



Үйлдвэрийн эргэлтийн усны сав, багтаамж - 200 м³



Ахуйн усны бохирын цэг,
багтаамж - 25 м³

Хог хаягдал

Үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хог хаягдлыг Налайх тохиуилт үйлчлээ ОНӨААҮГ-тай байгуулсан хог “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх” гэрээний дагуу тээвэрлүүлдэг. 2025 онд хамтран ажиллах гэрээг сунган ажиллах төлөвлөгөөтэй.



Хог хаягдал түр хадгалах цэг

Ахуйн бохир усыг “Чандмань-Налайх” НӨҮГ -тай байгуулсан “Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ”-ний дагуу Налайх дүүргээс зөвшөөрөгдсөн бохирын цэгт нийлүүлдэг.



Бохир ус соруулж, тээвэрлэх автомашин

Цахилгаан хангамж:

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор нь 7 км зайтай “УБЦТС” ТӨХК-ний 35кв/10кв-ийн дэд станцаас агаарын шугамын тэжээгдэнэ. Үйлдвэр агуулахын цогцолбор нь цахилгаан эрчим хүчийг 400кв-ийн трансформатортай хаалттай хувиарлах байгууламжаар 220/380В-н хүчдэлд хувирган хэрэглээндээ ашигладаг.



Төслийн цахилгаан үүсгүүр буюу 380В-ын трансформатор

Дулаан хангамж:

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын барилга байгууламжийг цахилгаанаар халаана.

Автомашинны зогсоол:

Хөрсний элэгдэл, тоос шороо агаар бохирдуулахаас сэргийлж тэсрэх бодисын үйлдвэр агуулахын түүхий эд буулгах талбай, тенхологийн зам болон автомашин зорчих хэсэг, явган хүний замыг засч бетоноор хучилттай.



ХОЁР.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна химийн бодисын онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт талаар ажиллагсад мэдлэг олгож, болзошгүй сөрөг нөлөөлөл, осол эрсдлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

Төслийн хэрэгжилтээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгалийн хам бүрдэл тус бүрийн хувьд дэлгэрүүлэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл
- Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл
- Усан орчинд үзүүлэх нөлөөлөл
- Ургамлан нөмрөгд үзүүлэх нөлөөлөл
- Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл
- Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Химийн бодис хадгалах агуулахын ойр орчим хог хаягдал ил задгай хаях, бодис суудаг талбайг хатуу хучилттай болгоогүйгээс хөрс усанд бохирдол тархах
- Үйлдвэрийн процесс бүр дээр аюулгүй байдал алдагдсанаас хөрс, агаар, усанд нөлөөлөл
- Автомашин, тээврийн хэрэгслийн дуу чимээ нэмэгдсэнээр ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьдрах орон зай нь хумигдах
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнтэй уялдан хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх
- Хог хаягдлаа замбараагүй хаявал гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Хийн хаягдал агаар орчин бохирдуулах
- Химийн бодис тээвэрлэх, хадгалах технологи үйл явцаа зөв зохион байгуулахгүй бол байгальд нөлөөлөл магадлалтай болохыг сайтар ухамсарлаж байх.

2.3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Төслийн явцад агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь автомашины утаа, санамсар болгоомжгүйгээс үүссэн химийн бодисын алдагдал үүнээс үүсэх хийн хагядал, тоосжилт байх боломжтой юм. Тоосжилтын эх үүсвэрүүд нь:

- Автобаазын агуулахын засвар үйлчилгээ, тохижилтын ажлын үед
- Түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн ачиж буулгах, бэлдэх талбай дээрх машин механизмын хөдөлгөөн, дуу чимээ
- ШТС агуулах, ШТМ алдагдах агаарын чанар
- Химийн бодис тээвэрлэж буй машинаас асарч болох шороо тоос

Төслийн талбайд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тухайн орон нутгийн тоосжилтийн түвшинг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болох бөгөөд агаарт дэгдэж буй тоосны улмаас үзэгдэх орчин багасаж осол, аваар гарч болзошгүй. Тоосжилтын улмаас төслийн ажилчид, ойр орчмын иргэдийн эрүүл мэнд болон эргэн тойрны байгаль орчинд зохих хэмжээгээр нөлөөлөл учир төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч буй тоосжилтийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:

Усны хэрэглээ ба шингэн хаягдал: Ажилчдын ахуйн хэрэглээ болон цайны газраас хоногт хаягдах ахуйн бохир шингэн хаягдал гарна. Нэг хүний усны хэрэглээний нормыг 2015 оны 7 сарын 30 ны өдөр батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах норм” –ыг үндэслэн тооцов. Нийт ажилчид 61 хүн, ажиллах бөгөөд хоногт 1 ажилчин дунджаар 80 л ус ашиглахаар тооцов.

Нэг өдөрт: Нийт ажилтан 61 хүн*80л/хон=4880 л сард буюу 30 хоногт 146400 л, жилд буюу 252 хоногт 1229.76 м³ ус ашиглахаар байна. Үүнээс 70% буюу 860.8м³/жилд шингэн хаягдал гарах тооцоотой байна.

Үйлдвэрийн түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн, химийн бодис тээвэрлэхэд ашиглаж буй тээврийн хэрэгслээс алдагдах шатахуун, агуулахын үйл ажиллагаанаас ил задгай хог хаягдал гадаргын урсацаар зөөгдөн тархах болзошгүй гэвч энэ тохиолдол үүсэхгүй байх магадлалтай. Учир нь бодис, нэгдлүүд нь сав баглаа боодлын хувьд битүүмжлэл сайтай.

- Хавар цас хайлах, зун намар эрчимжил ихтэй хур бороо орох үед замыг хөндлөн огтолж буй сайр, судгуудад богино хугацаанд урсац үүсэж, үерлэж болзошгүй.
- Хур тунадас, ялангуяа эрчим ихтэй бороогоор сайр, судгууд үерлэн зам, ус зайлуулах байгууламжийг эвдлэх тохиолдол үүсэж болзошгүй.
- Агуулахын орц гарцын хаалга ус орохооргүй байхаар хийх, төлөвлөх.
- Замын ус өнгөрөөх гаргалгаа зэрэг нь салхи ба усны урсгалаар байнга зөөгдөх хагшаасаар дүүрч хур борооны болон уруйн үерийн үед бөглөрч зохиомол үер үүсгэж, зам болон ус өнгөрөөх байгууламжийг эвдэлж, сэтэлж, гуу жалга үүсгэн нурааж болзошгүй.

2.3.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл:

Тэсрэх бодис тэсэлгээний үйлдвэр, химийн бодисын агуулахын хашаан доторх хөрсний байгалийн элэгдэл эвдрэлийн үйл явц харилцан адилгүй хэлбэрээр тохиолдох ба хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс хүчтэй эвдрэлд орсон газар байхгүй. Харин шороон замын хөрс машин техникийн нөлөөгөөр хүчтэй элэгдэл эвдрэлд орсноос хөрсний чулуужилт ихэссэн, зам дагуу тоосжилт ихтэйгээс ургамлан нөмрөг тоосжиж талхлагдсан зэрэг өөрчлөлттэй байна.

Хөрс элэгдэж эвдрэх, бохирдох нөлөөлөл агуулахыг барьж байгуулах үед болон салаа зам гарах, хөрс хуулах, түрэх, овоолго хийх, хучилт хийх, суваг шуудуу далан, барилга байгууламжийн ажлын үед хөрс, гадаргын урсацд өөрчлөлт орж хөрсний эвдрэл үүсэх бөгөөд үүнд бас газрын гадаргын хэвгий, хөрсний шинж чанар, гадаргын урсац, ургамалжилт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлнө.

- Үйлдвэрийн хашааны гадна, дотор явган хүний болон автозам тавихад ашиглагдах чулуу, шороо, цемент хийцийн үлдэгдлээр орчны хөрс бохирдоно. Мөн хөрсөнд эдгээр бохирдол нэвчих талтай.
- Хамгаалалтын сахиул айл, үйлдвэр, агуулах, байр талбай, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Хөрс их хэмжээгээр эвдэрч, бүтэц шинж чанараа алдан ургамлан нөмрөгөө устгуулах ба улмаар хөрснөөс хийсэх шорооны хэмжээ ихсэж цөлжилтийн үйл явцыг түргэсгэх болно.

Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл:

Ургамлан бүрхэвч нь мал болон зэрлэг амьтны тэжээл төдийгүй хөрсний дээд давхаргын дулаан ба чийгийг зохицуулагч, хөрс үүсгэгч, бэхжүүлэгч экосистемийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Ургамал нөмрөгийн талхагдал дунд зэрэг буй энэ орчимд хүн болоод техникийн нөлөөтэй талхагдалд нэлээд орсон байна.

Ургамлын нөмрөгт үзүүлэх шууд сөрөг нөлөөллийн хүчин зүйлүүд нь шороон зам, машин, хүний үйл ажиллагаанаас уг талбайнуудын ургамлын нөмрөг маш бага байна. Бүр мөсөн устах ургамлаас гаднах талбайн ургамлууд тоосжилт ба талхагдлаас шалтгаалж ургац бүтээмж доройтож, шарилж, лууль зэрэг хүмүүнсэг ургамал нэмэгдэх сөрөг нөлөөтэй. Үүнээс гадна барилгын ажлын явцад ургамлын нөмрөгийн болзошгүй хувьсал өөрчлөлт нь дараах хүчин зүйлээс шалтгаална. Үүнд:

- Хэт хуурайших, усан хангамж багасах, үер усны аюул нэмэгдсэнээс хөрсөн орчин өөрчлөгдөх хандлагатай болсон.
- Үйл ажиллагаа, автомашины замын тоос зэрэг нь ойр орчмын агаарыг тоосжуулахаас гадна, ургамлын навч бие эрхтэнд шороон тоос цугларч үйлдвэрийн болон түүний ойр хавийн ургамлын цаашдын амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Ургамлын ургац, үйл ажиллагаа явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтаны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй.
- Ургамлын бүрхэвч муудах устах зэргээс өвсөн тэжээлтэн амьтад устаж, тэдгээрийг барьж иддэг махчин амьтад ч дүрвэн зайлна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:

Тус төслийн талбай нь амьтны аймгийн хувьд төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Төслийн барилга байгууламжийг барих үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох, дараа нь үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлуулахгүй удах зэргээс болж орчны хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөөлөл:

Тухайн төсөл хэрэгжих талбай болон ойр орчим ямар нэгэн түүхийн дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Иймд энэхүү төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын дурсгалт зүйлс болон археологийн олдворт ямар нэгэн байдлаар нөлөөлөл байхгүй. Гэвч төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олох аваас холбогдох хууль тогтоомжид заасны засаг захиргааны анхдагч нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хувьд:

Төсөл хэрэгжиж буй талбай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд байрлах бөгөөд УТХГН-ын сүлжээтэй давхцалгүй байна. Хамгийн ойрхон байрлах УТХГН нь Богдхан уул байна.

ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй “Бласт” ХХК-ийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр

“Бласт” ХХК-ний үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тусгаж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж байх.

ДӨРӨВ.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад технологийн болон удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн БОНБНУ-ний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох хууль дүрэм журам стандартуудыг мөрдөн ажиллах юм.

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /Хэмжих нэгж/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
4.1 Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
1	Тоосжилт ба авто тээврээс үүсэх агаарын бохирдол	Агаарын чанарт нөлөөлөх нарийн ширхэгт тоосонцор болон хийн үзүүлэлтүүдийг хэмжих, стандарттай харьцуулах, дүгнэлт гаргах	Цогцолборын хэмжээнд/ Утааны нарийн ширхэглэгт тоосонцор, хорт хийн /агууламж	Жилд 2 удаа Тоосны хэмжээ, нийтлэг бохирдуулагч	ОХШ-ний зардалд төсөвлөсөн	2026 онд	MNS 4585:2016 Агаарын чанар. Ерөнхий шаардлага, MNS 4990:2000, ISO 4224, “Агаарын тухай” хууль
2	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ННН тооцоо	Тооллогын үр дүнд үндэслэн ялгарал бууруулах арга хэмжээ төлөвлөх /Уур амьсгалын өөрчлөлт (дэлхий дулааралд нөлөөлөх хий)	Инвентарчлал, тооцоо, шинжилгээ	Жилд 1 удаа (тооллого, хэмжилт)	-Дотоод төсөв	2026 онд	Хүлэмжийн хийн тооллогын аргачлал (УТХХТТ), MNS 4585:2016 Агаарын чанар, Химийн бодисын тухай хууль, MNS ISO 14064 стандарт
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх хорт хий, нүүрсхүчлийн ялгаралт	Тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд тогтмол хамруулах, засвар үйлчилгээ хийх	Салбарын автомашинуудад	Жилд 1 удаа	2.400.000	2026 онд	Засгийн газрын 192-р тогтоол — Тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийн журам
					2.400.000		

Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх хэлбэр	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба	Баримтлах хууль, журам, стандарт
4.2 Хөрсөн орчинд							
1	Өнгөн хөрсөн дээр ил задгай нүүрс, хаягдал материал буулгаснаас хөрс бохирдох эрсдэл	Нүүрс буулгалтын хуучин талбайг механик аргаар цэвэрлэх, бохирдсон хөрсийг ангилан зайлуулах	Уурын зуухны хажуу талбай	Цэвэрлэх талбай: 1,200–1,500 м ²	3.000.000	2026 онд 1удаа	MNS 5850:2008, MNS 5924:2015
2	Хөрсний элэгдэл, үржил шим буурах	Хөрсний чанарыг сайжруулах зорилгоор шинээр хөрс тархах,	Уурын зуухны хажуу талбай	15–20 м ³	Үйл ажиллагааны зардлаас	2026 онд 1удаа	“Газрын тухай” хууль, MNS 5914:2008
3	Талбайд дахин бохирдол үүсэхээс сэргийлэх	Талбайд дахин бохирдол үүсэхээс сэргийлж хашлага, тэмдэглэгээ тавих	Гадаах талбай	Жилд 1 удаа	500.000	2026 онд 1удаа	MNS 6561:2015 ХАБЭА тэмдэглэгээ
4	Хөрсөн орчин бохирдохоос арилгах, халдваргүйжүүлэлт хийх	Хөрсөн орчин бохирдох ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Төслийн талбайд	Жилд 2 удаа	550.000	Жил бүр	MNS 6800:2019 (ариутгал халдваргүйжүүлэлтийн ерөнхий шаардлага)
5	Хөрсөнд жившилт үүсэх, аюун цэвэрлэгээний байгууламжгүйгээс үүдэх эрсдэл	Хөрсөнд нэвчилтгүй ариун цэврийн байгууламж барих	Талбайн дотоод хэсэг	1 иж бүрдэл (ариун цэврийн байгууламж)	5.000.000	2026 онд 1удаа	Ажилчдын эрүүл ахуйн стандарт, MNS 5095:2011
					9.050.000		

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
4.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
1	Урт хугацаанд хэмнэлтгүй ашигласнаар усны нөөц хомсдох	- Ус хэмнэх технологи ашиглах/ борооны ус хуримтлуулах/ - Ажилчдад гүний усны үнэ цэнэ, хэмнэлтийн талаарх	Цогцолборын худаг, ажлын байрны бүх хэсэг (сургалт, тоолуурын акт)	- Усны хэрэглээ (м ³ /сар) - Хэмнэлт (%)	200.000 төг	Жилд 1 удаа сургалт, сар бүр хяналт	Ундны ус, эрүүл ахуйн шаардлага MNS 900:2010
2	Зөвшөөрөлгүй ус ашиглах, усны нөөц ашигласны төлбөр бүрэн төлөгдөхгүй байх	- Ус ашиглалтын дүгнэлт, гэрээ, зөвшөөрлийг журмын дагуу авах - Ашиглалтын тайланг улирал тутам хүргүүлэх - Усны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх	Цогцолборын үйл ажиллагааны бүс (бичиг баримт бүрдүүлэх, шошго тэмдэглэгээ)	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа Төлбөрийн баримтын тоо	500.000 төг	Жилд 1 удаа + жилийн эцсийн тайлан	Усны тухай хууль, Ус ашиглах зөвшөөрлийн журам
3	Зөвшөөрөлгүй ус ашиглах	- Усны тоолуурын баталгаажуулалт хийлгэх - Усны хэрэглээг бүртгэх - Усны алдагдал шалгах үзлэг	Усны тоолууртай бүх хэрэглэгчийн цэг	Баталгаажуулалтын гэрчилгээ (тоолуур баталгаажуулалт)	250.000 төг	Жилд 1 удаа	Усны тоолуур ашиглалтын техникийн шаардлага
4	Хаягдал усны дүгнэлт, ус зайлуулах гэрээ, зөвшөөрөлгүй ариутгах татуургат болон байгальд шууд нийлүүлэх	- Хаягдал усны лабораторийн шинжилгээ хийлгэх - Аюулгүй зайлуулах гэрээтэй байгууллагатай хамтрах	Цогцолборын хаягдал усны систем	- Шинжилгээний давтамж 1 удаа	400,000 төг	Үйл ажиллагааны турш, шинжилгээ сар бүр	MNS 4943:2015 – Хаягдал ус. Шингээлтийн шаардлага
					1,350,000		

ТАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Олборлолт явуулдаггүй.

№	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
5.1	Орчны тохижилтын зураг, Ногоон байгууламжийн уртын төлөвлөгөө гаргах	Нийт төслийн талбай	Жилд 1 удаа	-	2026 онд	MNS 6055:2009 Нөхөн сэргээлт, техникийн нөхөн сэргээлтийн шаардлага
5.2	Шалган нэвтрүүлэх цэгээс оффис хүртэлх зам дагуу амьд хашлага тарих	- Үйлдвэрийн барилга, оффисын гадна талбайд хөрсний нүд сэргээх ургац өгөх бут сөөг тарих	Нэг талдаа 100м ²	600.000	Жил бүр	Ойн тухай хууль, Байгаль орчин хамгаалах тухай хууль
5.3	Шалган нэвтрүүлэх гадаах зам дагуу амьд хашлага тарих	Үйлдвэрийн гадна орчин	Нэг талдаа 75 м ²	600.000	Жил бүр	Хот байгуулалтын норм, MNS 5914:2008 Ногоон байгууламж
5.4	Хоолны заалны гадаах орчныг тохижуулах		200 м ²	150.000	2026 онд	Хот байгуулалтын норм, MNS 5914:2008 Ногоон байгууламж
5.5	Ногоон байгууламжийн хүлэмжийн хийн шингээлтийн тооцоо гаргах	Байгаль орчны жилийн тайлан	Жилд 1 удаа	-	2026 онд	MNS ISO 14064–1:2019 Хүлэмжийн хий – Тооцоо
				1,350,000		

ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговор олгохгүй. Салбарын аюулгүйн бүст хүн ам суурьшсан төв байхгүй.

ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй.

Төсөл хэрэгжүүлэх явцад түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хирэгсүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд үйл ажиллагааг зогсоож, холбогдох байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хмагаалтанд авах шаардлагатай. Эдгээрийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.

“Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн зуравдугаар бүлгийн 12, 13-р зүйлд заасны дагуу газрын хэвлийг ашиглах явцад археологийн олдвор болон түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл гүйцэтгэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг шинжлэх ухаан болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөхийг хориглоно гэсэн заалтыг мөрдлөг болгоно.

НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Бодис, материалыг тоо хэмжээ, шинж чанараас хамааруулж агуулахуудад ангилж хадгалдаг. Агуулахын барилгуудыг холбогдох стандарт MNS6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн агуулах ерөнхий шаардлагад нийцүүлэн байгуулсан ба осол аюулын эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг холбогдох байгууллагаас гаргуулах замаар хүний буруу үйл ажиллагааны улмаас хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн ашиглалтын бүхий л үе шатанд байгаль орчин, хүний эрүүл мэндэд тохиолдож болзошгүй осол, аюул эрсдэл гаргахгүй байхад чиглэсэн үйл ажиллагааг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажилладаг.

Тэсрэх бодисын үл тэсрэх хольц бэлтгэх үйлдвэр нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд онцгой анхаардаг бөгөөд холбогдох хууль, журам, арга технологи болон компанийн дотоод журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

- Дотоод хяналт шалгалт хийх журам
- Нэвтрэн орох гарах журам
- Галын аюулгүй байдлыг хангах журам
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хэрэглэх түүнд хяналт тавих журам
- Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
- Гамшгийн эрсдлийн үнэлгээ
- Гал унтраах шуурхай төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээ ний цар хүрээ	Тоо хэмжээ э /хэмжи	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
8.Осол эрсдэлийн менежмент							
8.1	Агуулахын дүрэм, журам, хадгалалтын горим, нөхцөл зөрчигдөх	<ul style="list-style-type: none"> Химийн бодисын агуулахад тогтмол үзлэг, хяналт хийх Ажлын байрны агаарын чанар, температур, чийгшил шалгах Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах 	Агуулахад	Сар бүрийн хяналт	Дотоод төсөв (үзлэгийн материал, хамгаалах хэрэгсэл)	2026 онд	<ul style="list-style-type: none"> Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль • MNS 4967:2000 – Агуулахын аюулгүй ажиллагаа
8.2	Стандартын шаардлага хангаагүй хамгаалах хэрэгсэлээс үүдэн осол, гэмтэл гарах; хамгаалах хэрэгслийг үл зөв ашигласнаас эрсдэл нэмэгдэх.	Ажилчдыг ажлын онцлогт нийцсэн хамгаалах хувцас, хамгаалалттай гутал, малгай, бээлий, амны хаалт, сонсгол хамгаалагч болон өндөрт ажиллах хамгаалах бүс зэрэг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, бүртгэлжүүлэх.	Нийт ажилчид	жилд 1 удаа	Дотоод төсөв	Жил бүр	Эрүүл ахуйн тухай хууль, Ариутгал, халдваргүйжүүлэлтийн стандарт MNS 6458:2014
8.3	Галын осол аваараас урьдчилан сэргийлэх	<ul style="list-style-type: none"> Галын аюулгүй байдлын сургалт, дадлага зохион байгуулах Галын хор, тоног төхөөрөмжийн ашиглалтын үзлэг хийх 	Нийт ажилчид	жилд 1 удаа	-	2026 онд	<ul style="list-style-type: none"> Галын аюулгүй байдлын тухай хууль • MNS 2332:2015 – Галын хор
8.4	Хортон шавьж, мэргэчээр дамжих эрүүл ахуйн эрсдэл, халдвар, материалын гэмтэл	Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавьж мэргэч устгалын мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж тогтмол устгал хийх; Ил задгай хог, бохирдол үүсгэхгүй байх; Хог хадгалалтын талбайг цэвэр, битүү байлгах	Үйлдвэрийн бүс, агуулах, гадна талбай	Жилдээ 2 удаа	– (Гэрээт байгууллагын үйлчилгээний зардлаас хамаарна)	Хагас жил тутам	- Хог хаягдлын тухай хууль
8.5	<ul style="list-style-type: none"> Үерийн усны урсгал хаагдах, давхцах Ажлын талбай усанд автах эрсдэл Зам, байгууламж гэмтэх 	<ul style="list-style-type: none"> Шуудууг тогтмол цэвэрлэж, шороон бөглөрөл арилгах Ус зайлуулах сувгийг засварлаж шинэчлэх Урсацын чиглэл, налууг стандартын дагуу тохируулах 	Үйлдвэрийн бүс, гадна талбай	Жилд 1 удаа	400,000	2026 онд	<ul style="list-style-type: none"> “Гол, мөрний урсац, хамгаалалтын бүсийн тухай хууль” Барилгын норм ба дүрэм (БНБД) – ус зайлуулах байгууламжийн шаардлага
					400,000		

Осол эрсдэлийн менежмент

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Технологийн гаралтай хог хаягдал

Төслийн үйл ажиллагаас дараах төрлийн технологийн гаралтай хог хаягдал гарна. Үүнд:

- Түүхий эдийн шуудай
- Тэсрэх хэрэгслийн цаасан хайрцаг
- Техникийн тосны хоосон төмөр торх (бочка)
- Тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, тосолгооны бүтээгдэхүүний хаягдал
- Автомашины шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн хаягдал

Хог хаягдал тээвэрлэх 2301002 тоот гэрээг 2023 оны 01 дүгээр сард “Налайх тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай 2 жилийн хугацаатай, ахуйн бохир ус татан зайлуулах гэрээг “Чандмань Налайх” ХХК-тай байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж ажилладаг бөгөөд 2024 онд холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллана.

Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээг Түмэн эгшиг ХХК-тай жил бүр байгуулж, Түмэн эгшиг ХХК-тай жил бүр байгуулж, “АХХ-ыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах” журам, болон гэрээний дагуу түүхий эдийн сав, баглаа боодлыг дагалдах бичгийн хамт хөтлөн нийлүүлж байна.

Саармагжуулах, хоргүйжүүлэх судалгаа

Натрийн нитрит (NN01)

Бодис дээр карбонат натри ба усыг 1:1 харьцаагаар хийнэ. Дээр нь 6М давсны хүчлийн уусмал нэмж саармагжуулсны дараа уусмалын орчныг рН-6.0-9.0 болтол усаар шингэрүүлж бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаяна.

Азотын хүчил ([^]N03)

Кальцийн, натрийн гидроксид болон натрийн карбонатын (техникийн сод) 10-20%-ийн уусмалаар саармагжуулна. Азотын хүчлийг саармагжуулагч бодистой хольж 10 цаг орчим байлгана. Саармагжуулсны дараа уусмалын орчныг рН-6.5-8.0 болтол усаар шингэрүүлж, бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаяна.

Бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаях арга

- Биологийн задралд хялбар орох, бага хэмжээний органик бодисуудын хаягдлыг бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаяж болно
- Органик бус бодисын хаягдлыг энэ аргаар устгахдаа урьдчилан саармагжуулна
- Хялбар шатамхай, усанд уусдаггүй, биологийн задралд ордоггүй, бохир усны системд нөлөөтэй, зэврэлт үүсгэдэггүй, устай холилдохоороо хортой хий ялгаруулдаг бодисуудын хаягдлыг энэ аргаар устгахгүй

*Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Бласт” ХХК-ийн Налайх салбарын
2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Гол ба болзошгүй сөрөн нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
9.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө							
9.1	Зөвшөөрөлгүй хаях, хүрээлэн буй орчин бохирдуулах	Хог хаягдлын гэрээ байгуулж, ахуйн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх	Үйлдвэрийн хэмжээнд	-	500,000	Тогтмол	
9.2	Сав баглаа боодлын хэрэглээг бууруулах бодлого хэрэгжүүлэх	Дахивар хог хаягдлыг ангилан ялгаж, түүхий эд авагч байгууллагад нийлүүлэх	Үйлдвэрийн хэмжээнд	-	-	Тайлант онд тухай бүр	
9.3	Хог хаягдлын сургалт, дадлага явуулах	Ажилтнуудад хог ялгалт, аюултай хогийн эрсдэл, ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах	Үйлдвэрийн хэмжээнд	1 удаа	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	
9.4	Хаягдлын бүртгэл, тайлагналын цахим систем нэвтрүүлэх	Хог хаягдлын гаралт, ангилалт, тээвэрлэлт, гүйлгээг цахимаар бүртгэх	Үйлдвэрийн хэмжээнд	1	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	
					584,000		

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг “Бласт” ХХК -ийн удирдлага хүлээнэ.

№	Гол ба болзошгүй сөрөн нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хамрах хүрээ	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө							
10.1	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилтны эрүүл мэнд доройтож, өвчлөл нэмэгдэх нь хөдөлмөрийн чадвар буурч үйлдвэрлэлийн осол, эрсдэл өсөхөд хүрэх	Нийт ажилчид	Бүх ажилчид	(компанийн ЖСХ сангаас)	Жил бүр	ХАБЭА-н инженер, компанийн удирдлага
10.2	Хог хаягдлын ангилал, цэвэрлэгээний өдөр зохион байгуулах	Улирал бүр “Цэвэрлэгээний өдөр” хэрэгжүүлэх	Орчмын талбай	Бүх ажилчид	Дотоод төсөв	Жил бүр	Байгаль орчны мэргэжилтэн
10.3	Налайх дүүргийн зорилтот бүлгийн хүүхдүүдэд шинэ жил болон хүүхдийн баярын бэлэг гардуулж, нийгмийн сайн үйлсийн арга хэмжээг зохион байгуулах	Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн зорилтот бүлгийн хүүхдүүдийг дэмжих, сурч боловсрох орчныг сайжруулах, хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эерэг нөлөө үзүүлэх нийгмийн сайн үйлсийн арга хэмжээ зохион байгуулах.	Орон нутгийн зорилтот бүлгийн хүүхдүүд	Налайх дүүргийн 5–15 насны хүүхдүүд (тоог орон нутгийн байгууллагатай тохиролцоно)	2,000,000 – 5,000,000₮ (компанийн ЖСХ сангаас)	Жилд 2 удаа (Шинэ жилийн бэлэг, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр)	Компанийн удирдлага, Салбарын дарга,
10.4	Байгаль орчин, усны нөөцийн талаар олон нийтийн мэдлэг мэдээлэл дутмаг	Байгаль орчны өдөр, Усны өдрийн хүрээнд сургалт, нөлөөллийн аянд хамрагдах, байгууллага дотор танилцуулга семинар зохион байгуулах, мэдээллийн самбар байрлуулах	Бүх ажилтнууд болон орон нутгийн иргэд	Компанийн нийт ажилтнууд, Налайхын орон нутгийн төлөөлөл	500,000₮	Жил бүр /3 сар – Усны өдөр, 6 сар – Байгаль орчны өдөр/	Байгаль орчны мэргэжилтэн, ХАБЭА, Компанийн удирдлага
					500,000		

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчилан тогтоох боломжтой болно. Хяналт шинжилгээний дээж, сорьцийг МУ-ын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан арга зүй, стандартын дагуу шинжлүүлнэ.

№	Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа	Зардал /төг/	Баримтлах стандарт ба арга аргачлал
УСАН ОРЧИН					
9.1	Усны ерөнхий химийн шинжилгээ болон нян судлалын ерөнхий шинжилгээ	Үйлдвэрийн худаг Унд ахуйн хэрэглээ	Жилд 2 удаа	200'000	MNS 0900 : 2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
ХӨРСӨН ОРЧИН					
9.3	Хөрсний механик бүрэлдэхүүн, хүнд металлын шинжилгээ	Цогцолборын хашаан гадна болон дотор, хог хаягдлын цэгийн орчим	Жилд 1 удаа	150'000	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
АГААР					
9.4	Тоосжилт (PM10, PSM, PM25) Гадаад, дотоод орчин	Үйлдвэр, агуулахын хашааны гадна, хогийн цэг орчим	Жилд 2 удаа	200'000	MNS4990:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Нийт зардал				450'000	

АРВАН ХОЁР .ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	Оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Хугацаа, давтамж	Зардал /төг/ Зардал
1	Налайх дүүргийн 3-р хороо	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсан ажлыг мэдээлэх	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал
2	Нийслэлийн БОАЖГ-т	2026 оны БОМТ-ний биелэлтийн гүйцэтгэл тайланг цахимаар болон хэвлэж хүргүүлэх	11-р сард, Жилд 1 удаа	



БАТЛАВ. “БЛАСТ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал:

..... /А.ТЭМҮҮЛИН/

“БЛАСТ” ХХК-ийн “Налайх” салбарын Байгаль хамгаалах чиглэлээр
2026 онд хийгдэх ажлын төсөв.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугац	Зардал /төгрөг/	Хариуцах эзэн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө	2026 онд	12,800,000	Салбарын дарга; Байгаль орчны мэргэжилтэн
2	Орчны тохижилтын төлөвлөгөө	2026 онд	1,350,000	Салбарын дарга; Байгаль орчны мэргэжилтэн
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2026 онд	-	Салбарын дарга; Байгаль орчны мэргэжилтэн
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2026 онд	5,400,000	Салбарын дарга; Байгаль орчны мэргэжилтэн
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2026 онд	1,000,000	Салбарын дарга; Байгаль орчны мэргэжилтэн
7	Удирдлага зохион байгуулалт	2026 онд	582,000	Салбарын дарга; Байгаль орчны мэргэжилтэн
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2026 онд	548,000	Байгаль орчны мэргэжилтэн
	Дүн		21,680,000	

ХАВСРАЛТ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006.01.19

/Бүртгэсэн өн. сар. өдөр/

9011125047

/Улсын бүртгэлийн дугаар/

268036

/Регистрийн дугаар/

Бласт

Хянгартөндмөн хэрэгцээтэй компани

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсэн байгуулах баримт бичиг/

Тогтоол

/Амьдрэлийн нэр/

001

/Дугаар/

2001.09.11

өн. сар. өдөр

261200
код

Тэсрэх материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, импортолох, худалдаалах
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

311001

Гадаад худалдаа

код

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй
хугацаа

3

/Ашигүүдийн тоо/

11,700.0

/Өөрийн хөрөнгийн хэмжээ, мөнгөн тэнхлэгээр/

Хан-Уул, 1-р хороо, Чингэсийн өргөн чөлөө, "Тийс Бридж" зочид буудал - 203 туур, утас: 325555,
утас: 324044, факс:

/Хуулийн этгээдтэй илбэн ёсны хаяг/



Гэрчилгээг олгосон: 2006 оны 01 сар 19 өдөр

УХА0175

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

2022. оны .12. сарын 23. өдөр

Дугаар 864

Улаанбаатар хот

Эрхлэх үйл ажиллагааны төрөл

Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр

“БЛАСТ” ХХК

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Ландмарк оффис, 3 давхар

Регистрийн дугаар

2688336

Тусгай зөвшөөрлийн хугацаа

5 /Тав/ жил

Тусгай нөхцөл, шаардлага

Холбогдох хууль, журам, дүрэмд заасан бүх шаардлагыг хангаж ажиллах

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2022. 2 оны . 12. сарын . 23. өдрийн АЗ1А дугаар тушаалыг үндэслэн олгов.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД



Ж. ГАНБААТАР

А.Тухай жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

г. Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх

- 1.Төслийн хэрэгжүүлэгчийн нэр: "Бласт" ХХК
2. Үйл ажиллагааны чиглэл: Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор
- 3.Төслийн байршил: Налайх дүүрэг 3 дугаар хороо
- 4.Огноо: 2025 он 12 сарын 05 өдөр


№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо						Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6		
	1	2	3	4	5	6	7	8	10	11
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	20	18	20	19	18	19		
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	15	10	15	10	12	12	13		
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	5	5	5	5	5		
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	20	25	17	20	19	20	18		
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	20	20	18	20	19	20	20		
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10	10	10	10	9	10	10		
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5		
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	0	4	3	3		
	Нийт оноо	100	90	93	90	92	93	93	91,8	


Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-ээс доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.


Ажлын хэсгийн дарга:  /Э.Жаргалсайхан/ (Гишүүн 1) 99883932

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:  /Г.Цэцэнбилэг/ (Гишүүн 2) 90001513

Гишүүд:

Нийслэлийн Байгаль орчны газрын хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч  /Ш.Калибек/ (Гишүүн 3) 91112227

Туул голын сав газрын захиргааны Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн  /Э.Эрдэнэцэгэл/ (Гишүүн 4) 99397388

Налайх дүүргийн ЗДТГ-ын Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн  /Б.Батчимэг/ (Гишүүн 5) 88139901

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл  /Н.Нямнамбаял/ (Гишүүн 6) 99885073

Хүлээн зөвшөөрсөн

Бласт ХХК-ийн Гүйцэтгэх захирал  /А.Тэмүүлүн/ 99112528

Н.Д 3-р хороо
Замчны 15-107

Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2025.03.26 17:07:30

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 233233181

Системийн огноо: 2025.03.26

Нэр: **БЛАСТ ХХК**

Илгээгч	Дансны дугаар: 463015533	Нэр БЛАСТ ХХК	Дүн 4,100,000.00 MNT	Ханш 1.00
<i>/ дөрвөн сая нэг зуун мянган төгрөг /</i>				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90 Дансны дугаар 100900013406	Банкны нэр Төрийн сан Нэр БО нөхөн сэргээх баталгаа	4,100,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга:

ЕВ -БОНБ үнэлгээний барьцаа байршуулах Налайх

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг: